

ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН ТҮҮНД ХАМААРАХ ЭРХИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Оюуны өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт заасан, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ -ийн үйл ажиллагаанд энэхүү журмыг баримтлан ажиллана.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1 Зөвлөлийн үйл ажиллагаанд Оюуны өмчийн газар дэмжлэг үзүүлнэ.

2.2 Зөвлөл нь холбогдох асуудлаар тогтоол, зөвлөмж гаргаж тухайн шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна.

2.3. Зөвлөлийн шийдвэрээр тухайлсан асуудлаар мэргэжлийн салбар зөвлөл, шинжээчдийн баг ажиллуулж болно.

2.4 Зөвлөл нь хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэж болно.

2.5.Зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, гишүүдээс бүрдсэн 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллана.

2.6. Зөвлөлийн гишүүд нь холбогдох яам, агентлаг болон нийслэлийн байгууллага, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

2.7. Зөвлөлийн бүрэлдэхүүнд энэхүү журмын хавсралтад дурдсан Төрийн болон Нийслэлийн байгууллагын төлөөлөл болох гишүүд шууд /албан тушаалаараа/ томилогдоно.

2.8. Хавсралтад дурдсан төрийн бус байгууллагуудаас тус бүр 1 хүнийг зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ. Зөвлөлийн бусад гишүүдийг дээрхи нэр дэвшигчдээс Оюуны өмчийн газрын дарга сонгож, 2 жилийн хугацаагаар томилно.

2.8 Зөвлөлийн гишүүд 1 удаа 2 жилээр улиран сонгогдох эрхтэй.

2.9.Зөвлөлийн дарга, орлогч даргыг нийт гишүүдийн дундаас ердийн олонхын саналаар сонгоно.

2.10 Зөвлөлийн гишүүн чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн, хугацаа дууссан, нас барсан, өвчний улмаас цаашид ажиллах боломжгүй болсон зэрэг болон бусад шалтгааны улмаас орон тоо гарсан тохиолдолд гишүүнийг тухай бүр нөхөн томилно.

2.11 Зөвлөлийн нарийн бичгийн даргаар Оюуны өмчийн газрын Зохиогчийн эрхийн хэлтсийн мэргэжилтэн ажиллана.

Гурав. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөлийн чиг үүрэг

3.1.Зөвлөл нь Оюуны өмчийн тухай хуулийн 11.4 дүгээр зүйлийн дагуу дараахи чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Зохиогчийн эрхийн хамтын удирдлагын байгууллагуудын лицензийн гэрээний тарифын дээд хязгаарыг тогтоох;

3.1.2. Зөвлөлөөс тогтоосон тарифыг мөрдөж ажиллах талаар болон холбогдох бусад асуудлаар тогтоол, зөвлөмж гаргаж холбогдох газруудад хүргүүлэх;

3.1.3. Тарифыг тогтоохтой холбоотой шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээлэл, судалгааг холбогдох этгээдээс гаргуулж авах;

3.1.4. Тарифын асуудлыг хэлэлцэхдээ холбогдох газруудын төлөөллүүдийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, тарифын талаар зөвшилцөх,

3.1.5.Хамтын удирдлагын байгууллагаас санал болгож байгаа зохиогчийн эрхийн бүтээл ашиглуулах лицензийн гэрээний тарифыг хянах, зөвшилцөх;

3.1.6.Зохиогчийн эрхтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд болон уран бүтээлчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сургалт, хөтөлбөр боловсруулах, соён гэгээрүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж гаргах;

3.1.7.Зохиогчийн эрхийн чиглэлээр гарч буй хууль тогтоомж, хөтөлбөр, заавар, зөвлөмжийг боловсруулах, түүний онолын түвшин, практик ач холбогдлыг дээшлүүлэхэд албан ёсны санал, зөвлөмж, хөтөлбөр гаргаж Оюуны өмчийн газарт хүргүүлэх;

3.1.8."Оюуны өмчийн шилдэг бүтээл" шалгаруулах шагналд нэр дэвшсэн зохиогчийн эрхийн бүтээлд тодорхойлолт гаргаж өгөх;

3.1.9. Зөвлөлөөс гарсан тогтоол,зөвлөмжийг зохиогчийн эрхийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа холбогдох байгууллагууд болон зохиогчийн эрхийн бүтээл ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө;

Дөрөв. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөлийн үйл ажиллагаа

4.1.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

4.2.Зөвлөл хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Хурлыг зөвлөлийн дарга зарлаж, даргалах бөгөөд түүний түр эзгүйд орлогч дарга зарлаж болно.

4.3.Зөвлөлийн дарга шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

4.4.Хурлын товыг хуралдаан болохоос 7-гоос доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох баримт бичгийг хүргүүлсэн байна.

4.5.Нийт гишүүдийн олонх оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно.

4.6.Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд биеэр оролцох боломжгүй гишүүн хурал эхлэхээс 1 хоногийн өмнө саналаа бичгээр ирүүлж болно.

4.7.Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн хуралдаанд мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно;

4.8.Оюуны өмчийн тухай хуулийн 24.2.5-т заасныг үндэслэн зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын хэмжээг Оюуны өмчийн газрын дарга тогтоож жилд 2 удаа хагас болон бүтэн жилээр олгоно;

4.9.Хурлын тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлнө.

4.10 Зөвлөл нь жил бүрийн эцэст үйл ажиллагааныхаа тайланг олон нийтэд танилцуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

Тав. Нарийн бичгийн даргын үүрэг

5.1.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулж, хуралдааны бэлтгэлийг хангаж, гарсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн, зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүдийг мэдээллээр хангана.

5.2.Зөвлөлийн нарийн бичгийн дарга зөвлөлийн бичиг хэргийг зохих журмын дагуу хөтлөн явуулна.

5.3.Зөвлөлөөс мэргэжлийн салбар зөвлөл, шинжээчдийн баг ажиллуулсан тохиолдолд зөвлөлийн нарийн бичгийн дарга тэдгээрийг өдөр тутмын удирдлагаар хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулна.

ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1.Төрийн болон Нийслэлийн захиргааны байгууллага

- Хууль зүй дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, инновацийн асуудал хариуцсан газрын дарга
- Соёлын яамны Урлагын асуудал хариуцсан газрын дарга
- Оюуны өмчийн газрын Зохиогчийн эрхийн хэлтсийн дарга
- Соёл урлагийн газрын Урлагын асуудал хариуцсан хэлтсийн дарга

2. Нийслэлийн байгууллагууд

- Нийслэлийн соёл урлагийн газрын Урлагын асуудал хариуцсан хэлтсийн дарга, мэргэжилтэн

3. Төрийн бус байгууллага

- Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо /зөвшилцсөнөөр/
- Шинжлэх ухааны академийн төлөөлөл
- Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны төлөөлөл
- Монголын телевизүүдийн холбооны төлөөлөл
- Урлагын зөвлөлийн төлөөлөл
- Монгол кино нэгтгэлийн төлөөлөл
- Соёл урлагийн их сургуулийн төлөөлөл
- Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн төлөөлөл
- Дуурийн театрын төлөөлөл
- Драммын театрын төлөөлөл
- Караоке болон кино театруудын төлөөлөл
- Тоглолт зохион байгуулагч байгууллагуудын төлөөлөл
- Монголын нийтийн дуучдын нэгдсэн холбоо